



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
СҮМБЭР СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2016 оны 03 сарын 14 өдөр

Дугаар А/36

Чойр

Газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалт
явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, 33 дугаар зүйлийн 33.1.2, Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолын 7 дугаар хавсралтаар батлагдсан "Газар эзэмших төсөл сонгон шалгаруулалт явуулах журам" Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 01 дүгээр сарын 27 -ны өдрийн 13 дугаар тогтоолоор батлагдсан 2016 оны "Газар зохион байгуулалтын төлөвлөгөө"-г тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сүмбэр сум 1 дүгээр баг Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ төрийн өмчит хувьцаат компаний баруун урд байрлах 50Мвт-ын нарны цахилгаан станцын зориулалттай 100 га газрыг төсөл сонгон шалгаруулалтаар явуулсугай.
2. Газрыг олон нийтэд нээлттэй зарлаж, төсөл сонгон шалгаруулалтыг журмын дагуу зохион байгуулахыг Газрын даамал /Б.Баасанбат/-д даалгасугай.

ДАРГА  З.БАЯРСАЙХАН